



**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**  
FINANCIAL REGULATORY COMMISSION  
OF MONGOLIA

**ДААТГАЛЫН САЛБАРЫН 2015 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН  
САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ  
2016 оны 3 дугаар сар

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ГҮЙЦЭТГЭГЧ, ДЭД ДАРГА

Э. БАТБОЛД

ДЭД ДАРГА

Х. БУМ-ЭРДЭНЭ

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Ц.НАЦАГДОРЖ

ХЯНАСАН:

ДААТГАЛЫН ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА

Г.ХОНГОР

ДЗГ-ЫН ДБХХ-ИЙН ДАРГА

П.УУГАНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ДЗГ-ЫН ДБХ-ИЙН  
ХЯНАН ШАЛГАГЧ

Ц.ДАШНЯМ

## ГАРЧИГ

<b>1. ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>3</b>
1.1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ	3
1.2. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ	4
1.3. ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	6
1.4. ДААТГАЛЫН ХУРААМЖ	8
1.5. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР	10
1.6. ДААТГАЛЫН НӨӨЦ САН	12
1.7. ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА	12
1.8. ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА	14
1.9. ДАВХАР ДААТГАЛ	15
<b>2. ЕРДИЙН ДААТГАЛ</b>	<b>16</b>
2.1. ЕРДИЙН ДААТГАГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ	16
2.2. ЕРДИЙН ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	16
2.3. ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ	17
2.4. ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР	17
2.5. ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА, АШИГТ АЖИЛЛАГАА	17
2.6. ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН, ДАВХАР ДААТГАЛ	18
<b>3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ</b>	<b>20</b>
3.1. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ	20
3.2. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР	20
3.3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ	21
3.4. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН НӨӨЦ САН, АШИГТ АЖИЛЛАГАА	21
<b>4. АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ</b>	<b>22</b>
<b>5. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ</b>	<b>23</b>
5.1. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ	23
5.2. ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	25
<b>6. ДҮГНЭЛТ</b>	<b>27</b>

## 1. ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

### 1.1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2015 оны 4 дүгээр улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, хөдөө аж ахуйн давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 37, даатгалын хохирол үнэлэгч 27 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Мөн даатгалын компанийн салбар болон төлөөлөгчийн газар 255, даатгалын зуучлагч компанийн 174 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 52 салбар Хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа нь арилжааны даатгалын борлуулалтын сувгийг нэмэгдүүлж, иргэдэд хүрэх даатгалын хүртээмжийг нэмэгдүүлж байна.

Хүснэгт -1

#### Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

№		2009	2010	2011	2012	2013	2014	2015
1	Ердийн даатгалын компани	17	16	16	17	16	16	15
2	Урт хугацааны даатгалын компани	1	1	1	1	1	1	1
3	Давхар даатгалын компани							1
4	Даатгалын төлөөлөгч	1676	2061	2057	2357	3187	3260	3340
5	Даатгалын зуучлагч	5	9	8	17	20	30	37
6	Даатгалын хохирол үнэлэгч	2	6	9	9	14	20	27
7	Актуарч	10	12	13	18	15	15	15
	<b>БҮГД</b>	<b>1711</b>	<b>2105</b>	<b>2104</b>	<b>2419</b>	<b>3253</b>	<b>3244</b>	<b>3436</b>

Хүснэгт-2


#### Даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогч компаниудын салбарын тоо

№		2013	2014	2015
1	Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газар	251	254	255
2	Даатгалын зуучлагч компанийн салбар	64	135	174
3	Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар	8	42	52
	<b>БҮГД</b>	<b>323</b>	<b>431</b>	<b>481</b>

**2015 оны 4-р улиралд:** Хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 390 дугаар тогтоолоор “Монголиан иншуранс брокерейж” ХХК, 391 дүгээр тогтоолоор “Ай ай би” ХХК, 12 дугаар сарын 17-ны өдрийн 437 дугаар тогтоолоор “Тод капитал” ХХК-ууд даатгалын зуучлалын чиглэлээр, 12 дугаар сарын 17-ний өдрийн 435 дугаар тогтоолоор “Аа аперейзал” ХХК, 436 дугаар тогтоолоор “Виннэрвэй” ХХК, 438 дугаар тогтоолоор “Тэнцвэр эстимэйт” ХХК-ууд даатгалын хохирол үнэлгээний чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгосон байна.

## 1.2. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ


Тайлант хугацаанд давхар даатгалын болон даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 173.2 тэрбум төгрөг байгаа нь өмнөх тайлант он буюу 2014 оны 4 дүгээр улиралтай харьцуулахад 20.7 тэрбум төгрөгөөр буюу 13.6 хувиар өссөн байна. Үүнд 2015 оны 1 дүгээр сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хөрөнгө гол нөлөөлсөн. Гэвч салбарын хэмжээнд нийт хөрөнгийн өсөлтийн хурдыг авч үзвэл сүүлийн 5 жилийн дундаж өсөлтөөс бага байгаа бөгөөд энэ нь ердийн болон урт хугацааны даатгалын компаниудын нийт хөрөнгийн өсөлтийн хурдаас хамаарч байна.



Салбарын хэмжээнд нийт хөрөнгөд эзлэх хувиар авч үзвэл ердийн даатгалын компаниудын хөрөнгө 80.5 хувийг эзэлж байгаа нь урт хугацааны буюу амьдралын даатгал, давхар даатгалын тогтолцооны хувьд зах зээлд эзлэх байр суурь бага байгааг харуулж байна. Даатгалын тогтолцоо нь төлөвшсөн, харьцангуй өндөр хөгжсөн улс орнуудад амьдралын даатгал, давхар даатгалын систем нь салбарт эзлэх хөрөнгийн хэмжээ, даатгалын үйл ажиллагаагаар дийлэнх хувийг нь эзэлдэг байна. Гэвч манай улсад даатгалын салбар үүсэж хөгжиж ирсэн хугацаа, хүн амын тоо, зах зээлийн хэмжээ зэргээс хамаарч гадаад улс орнуудтай шууд харьцуулахад учир дутагдалтай юм.

График-2

### Салбарын хэмжээнд нийт хөрөнгөд эзлэх хувь



Хүснэгт-3

### Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ

№	Компани	Нийт хөрөнгийн хэмжээ			Компаниудын хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь
		Эргэлтийн хөрөнгө	Эргэлтийн бус хөрөнгө	Хөрөнгө	
1	Ард даатгал	7,206,802,617.72	1,551,722,689.65	8,758,525,307.37	5.06%
2	Бодь даатгал	9,255,036,992.19	1,764,133,176.65	11,019,170,168.84	6.36%
3	Ган зам даатгал	5,552,973,859.58	155,338,038.44	5,708,311,898.02	3.30%
4	Гэр даатгал	4,965,596,000.47	42,254,562.53	5,007,850,563.00	2.89%
5	Мандал женерал даатгал	9,191,415,321.98	605,885,133.94	9,797,300,455.92	5.66%
6	Миг даатгал	8,304,078,253.32	2,085,054,472.67	10,389,132,725.99	6.00%
7	Монгол даатгал	17,732,049,176.50	10,155,533,952.72	27,887,583,129.22	16.10%
8	Монре даатгал	4,997,171,657.26	808,459,971.53	5,805,631,628.79	3.35%
9	Мөнх даатгал	3,268,459,660.00	1,060,850,394.00	4,329,310,054.00	2.50%
10	Номин даатгал	8,339,642,108.11	0.00	8,339,642,108.11	4.82%
11	Нэйшнл лайф даатгал	4,722,048,487.60	2,912,030,274.00	7,634,078,761.60	4.41%
12	Практикал даатгал	7,662,073,756.03	1,373,212,982.38	9,035,286,738.41	5.22%
13	Соёмбо даатгал	6,728,795,465.34	2,560,639,667.51	9,289,435,132.85	5.36%
14	Тэнгэр даатгал	11,490,992,816.36	1,198,007,215.08	12,689,000,031.44	7.33%
15	Улаанбаатар хотын даатгал	3,990,608,208.29	1,687,702,995.41	5,678,311,203.70	3.28%
16	Хаан даатгал	4,894,468,006.18	881,225,545.81	5,775,693,551.99	3.33%
17	Хөдөө аж ахуйн давхар даатгал	25,669,518,101.29	386,322,803.73	26,055,840,905.02	15.04%
	<b>НИЙТ</b>	<b>143,971,730,488.22</b>	<b>29,228,373,876.05</b>	<b>173,200,104,364.27</b>	<b>100%</b>

Нийт хөрөнгөөс эргэлтийн хөрөнгийг бүтцээр нь авч үзвэл 79.9 тэрбум төгрөгийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, 28.5 тэрбум төгрөгийн богино хугацаатай хөрөнгө оруулалт, 14.9 тэрбум төгрөгийн дансны авлага, 20.6 тэрбум төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгөтэй байна. Эргэлтийн хөрөнгө нь нийт дүнгээрээ өмнөх оны мөн үеэс 18.3 тэрбум төгрөгөөр буюу 14.5 хувиар өссөн байна.


Хүснэгт-4

### Эргэлтийн хөрөнгийн бүтэц

Үзүүлэлтүүд	2014-IV	2015-IV	Өсөлт /бууралт/
-------------	---------	---------	-----------------

	төгрөгөөр	Эзлэх хувь	төгрөгөөр	Эзлэх хувь	төгрөгөөр	хувиар
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	75,530,936,989.6	60.1%	79,933,068,839.4	55.5%	4,402,131,849.8	5.8
Богино хугацаат хөрөнгө оруулалт	26,076,520,664.3	20.7%	28,508,322,070.2	19.8%	2,431,801,405.9	9.3
Дансны авлага	20,844,342,165.7	16.6%	14,951,170,822.5	10.4%	(5,893,171,343.2)	(28.3)
Бусад эргэлтийн хөрөнгө	3,243,835,018.7	2.6%	20,579,168,756.1	14.3%	17,335,333,737.4	534.4
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>125,695,634,838.2</b>		<b>143,971,730,488.2</b>		<b>18,276,095,650.0</b>	<b>14.5</b>

График-3




### 1.3. ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

2015 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөр 5.5 тэрбум төгрөгөөр буурч, нөөц сан 6.7 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 19.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Өмнөх оны мөн үеэс хамгийн өндөр өсөлт үзүүлж 26.0 хувиар өссөн эзэмшигчдийн өмчийн өсөлтөд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн эзэмшигчдийн өмчийн хэмжээ хүчтэй нөлөө үзүүлсэн байна. Тайлант улирлын даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, өр төлбөр, эзэмшигчдийн өмчийн эзлэх хэмжээг сүүлийн 5 жилээр харьцуулж график 4-г харуулав. Мөн хүснэгт 5, 6-д дэлгэрэнгүй тоон мэдээллийг нэгтгэсэн.

График-4

**Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба**  
**эзэмшигчдийн өмч /тэрбум төгрөг/**



Хүснэгт-5

Үзүүлэлтүүд	2014-IV		2015-IV		Өсөлт, бууралт	
	төгрөгөөр	эзлэх хувь	төгрөгөөр	эзлэх хувь	төгрөгөөр	хувиар
Өр төлбөр	11,619,497,219.4	7.6%	6,113,344,147.6	3.5%	(5,506,153,071.7)	(47.4)
Нөөц сан	66,113,588,930.0	43.3%	72,830,932,766.6	42.1%	6,717,343,836.6	10.2
Эзэмшигчийн өмч	74,804,989,100.6	49.0%	94,255,827,450.0	54.4%	19,450,838,349.5	26.0
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>152,538,075,249.9</b>	<b>100.0%</b>	<b>173,200,104,364.3</b>	<b>100.0%</b>	<b>20,662,029,114.4</b>	<b>13.5</b>

Хүснэгт-6

Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

№	Компани	Нийт төлбөр		Эзэмшигчдийн өмч	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч
		Өр төлбөр	Нөөц сан		
1	Ард даатгал	415,536,425.23	4,531,616,292.70	3,811,372,589.44	8,758,525,307.37
2	Бодь даатгал	451,564,133.42	6,809,569,979.28	3,758,036,056.14	11,019,170,168.84
3	Ган зам даатгал	78,509,574.00	937,781,472.55	4,692,020,851.47	5,708,311,898.02
4	Гэр даатгал	92,196,710.69	912,160,466.23	4,003,493,386.08	5,007,850,563.00
5	Мандал женерал даатгал	1,016,653,734.67	3,967,529,158.71	4,813,117,562.54	9,797,300,455.92
6	Миг даатгал	178,779,164.97	4,874,773,313.00	5,335,580,248.02	10,389,132,725.99
7	Монгол даатгал	1,659,362,060.83	16,132,955,233.76	10,095,265,834.63	27,887,583,129.22
8	Монре даатгал	125,468,473.17	1,802,492,865.18	3,877,670,290.44	5,805,631,628.79
9	Мөнх даатгал	2,991,230.00	607,604,862.00	3,718,713,962.00	4,329,310,054.00
10	Номин даатгал	123,861,100.68	4,581,001,765.52	3,634,779,241.91	8,339,642,108.11
11	Нэйшнл лайф даатгал	15,414,144.34	1,471,907,199.57	6,146,757,417.69	7,634,078,761.60
12	Практикал даатгал	106,557,796.05	4,489,223,953.18	4,439,504,989.18	9,035,286,738.41
13	Соёмбо даатгал	352,065,482.91	3,936,243,120.61	5,001,126,529.33	9,289,435,132.85



14	Тэнгэр даатгал	1,218,902,506.73	6,853,312,190.32	4,616,785,334.39	12,689,000,031.44
15	Улаанбаатар хотын даатгал	119,293,671.80	1,304,819,827.32	4,254,197,704.58	5,678,311,203.70
16	Хаан даатгал	116,846,400.55	2,026,884,419.31	3,631,962,732.13	5,775,693,551.99
17	ХАА-н давхар даатгал	39,341,537.58	7,591,056,647.38	18,425,442,720.06	26,055,840,905.02
	<b>НИЙТ</b>	<b>6,113,344,147.62</b>	<b>72,830,932,766.62</b>	<b>94,255,827,450.03</b>	<b>173,200,104,364.27</b>

#### 1.4. ДААТГАЛЫН ХУРААМЖ

Тайлант хугацаанд даатгалын компаниуд 1030814 иргэн, албан байгууллагатай даатгалын гэрээ байгуулж, 113.9 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсэн байна. Даатгалын нийт хураамжийн орлогын 98.5 хувь буюу 112.2 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 1.5 хувь буюу 1.7 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани төвлөрүүлсэн байна. Даатгалын компаниудаас 20 тэрбум ба түүнээс дээш төгрөгийн даатгалын нийт хураамжийн орлого төвлөрүүлсэн 2 даатгалын компанид зах зээлийн нийт хураамжийн орлогын 45.4 хувь нь ногдож байна. Энэ жилийн даатгалын нийт хураамжийн орлогын өсөлтийн хувь нь сүүлийн 5 жилийн дундаж өсөлтийн хувиас даруй 6.6 дахин бага байна.



Хүснэгт-7

#### Даатгалын хураамж

№	Даатгалын компани	Даатгалын нийт хураамжийн орлого	Давхар даатгалын хураамж	Буцаасан даатгалын хураамж	Даатгалын цэвэр хураамжийн орлого
1	Ард даатгал	9,159,626,509.99	1,841,974,596.96	239,053,564.17	7,078,598,348.86
2	Бодь даатгал	26,977,146,226.03	18,479,216,645.63	211,371,009.32	8,286,558,571.08
3	Ган зам даатгал	517,800,140.60	0.00	690,029.03	517,110,111.57
4	Гэр даатгал	428,551,328.77	0.00	1,902,453.50	426,648,875.27
5	Мандал женерал даатгал	9,183,892,109.72	5,783,971,377.54	230,320,832.28	3,169,599,899.90
6	Миг даатгал	10,031,507,271.10	1,067,097,151.69	212,834,647.69	8,751,575,471.72
7	Монгол даатгал	24,689,090,464.62	11,311,706,301.30	467,260,807.64	12,910,123,355.68

8	<b>Монре даатгал</b>	3,024,493,267.65	191,367,922.73	117,439,650.83	2,715,685,694.09
9	<b>Мөнх даатгал</b>	490,329,881.00	0.00	0.00	490,329,881.00
10	<b>Номин даатгал</b>	3,869,505,192.03	238,187,741.03	94,369,590.88	3,536,947,860.12
11	<b>Нэйшнл лайф даатгал</b>	1,652,826,227.62	24,805,093.00	0.00	1,628,021,134.62
12	<b>Практикал даатгал</b>	5,292,902,757.21	467,280,242.83	125,750,761.65	4,699,871,752.73
13	<b>Соёмбо даатгал</b>	5,354,832,633.11	534,823,534.46	211,300,085.74	4,608,709,012.91
14	<b>Тэнгэр даатгал</b>	8,663,979,895.35	1,949,258,415.03	250,679,848.73	6,464,041,631.59
15	<b>Улаанбаатар хотын даатгал</b>	1,078,447,671.19	0.00	722,000.00	1,077,725,671.19
16	<b>Хаан даатгал</b>	3,451,227,222.22	67,779,613.89	57,777,260.38	3,325,670,347.95
	<b>НИЙТ</b>	113,866,158,798.21	41,957,468,636.09	2,221,472,541.84	69,687,217,620.28

Тайлант хугацааны даатгалын нийт хураамжийн орлогын 85.5 хувь нь даатгалын 5 хэлбэрийн хураамжийн орлогоос бүрдэж байна. Нийт хураамжийн орлогын бүтцээс үзэхэд 36 хувийг хөрөнгийн даатгал, 20 хувийг ЖХАЖД, 14 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 6 хувийг хариуцлагын даатгал, 9 хувийг гэнэтийн ослын даатгалын хураамж тус тус эзэлж байна.

Хүснэгт-8

**Даатгалын хураамж /хэлбэрээр/**


№	Даатгалын хэлбэр	Даатгалын нийт хураамжийн орлого		Өсөлт, бууралт /хувиар/
		2014.12.31	2015.12.31	
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	10,125,765,156.16	10,612,015,862.25	4.8
2	Хөрөнгийн даатгал	32,266,796,545.58	40,884,297,808.37	26.7
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	18,277,609,615.26	15,676,414,189.47	(14.2)
4	Ачааны даатгал	3,190,239,256.60	2,375,826,966.02	(25.5)
5	Барилга угсралтын даатгал	1,433,700,225.65	2,002,547,549.95	39.7
6	Газар тариалангийн даатгал	0.0	0.0	-
7	Мал амьтдын даатгал	890,320,295.58	709,666,385.65	(20.3)
8	Агаарын хөлгийн даатгал	6,461,921,609.45	3,489,678,425.53	(46.0)
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	424,334,337.05	389,586,492.00	(8.2)
10	Хариуцлагын даатгал	5,912,049,322.48	7,335,783,807.53	24.1
11	Санхүүгийн даатгал	3,259,460,765.19	3,197,292,592.54	(1.9)
12	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	20,088,798,626.05	22,927,430,530.51	14.1
13	Зээлийн даатгал	2,707,556,029.94	769,849,914.35	(71.6)
14	Итгэлцлийн даатгал	61,651,242.75	25,292,935.70	(59.0)
15	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	0.0	0.0	-
16	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	0.0	0.0	-
17	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	2,205,429,444.40	1,817,649,110.72	(17.6)
18	Хугацаат амьдралын даатгал	269,754,441.43	345,164,043.78	28.0
19	Насан туршийн даатгал	-	0.0	-
20	Хуримтлалын даатгал	100,596,411.29	75,148,081.52	(25.3)
21	Тэтгэврийн даатгал	62,130,315.15	47,873,111.42	(22.9)
22	Эрүүл мэндийн даатгал	1,008,569,161.75	1,184,640,990.90	17.5
23	Аннуити	0.0	0.0	-

	<b>Нийт</b>	108,746,682,801.76	113,866,158,798.21	4.7
--	-------------	--------------------	--------------------	-----

Тайлант хугацаанд даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчдын даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлт нь дараах байдалтай байна. Даатгалын хураамжийн орлого төвлүүлэлтийн энэхүү тоон мэдээллийг даатгалын компаниудын тайлангаас нэгтгэсэн болно.

График-6

**Даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлт**




### 1.5. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Тайлант хугацаанд даатгалын тохиолдлын улмаас нийт 66012 даатгалын гэрээнд 36.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Тайлант хугацаанд “Монгол даатгал” ХХК 8.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь хамгийн өндөр бөгөөд нийт нөхөн төлбөрийн 22.1 хувийг эзэлж байна. Даатгалын компаниудын тайлант улирлын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “УБ хотын даатгал” ХХК-ийн нийт нөхөн төлбөр 5.1 дахин, “Мандал женерал даатгал” ХХК-ийн нөхөн төлбөр 2.9 дахин өссөн нь компанийн тухайд өндөр өсөлтийг харуулж байгаа бөгөөд үүнд “УБ хотын даатгал” ХХК-ийн автотээврийн хэрэгслийн даатгалын хэлбэрийн, “Мандал женерал даатгал” ХХК-ийн автотээврийн хэрэгслийн даатгалын болон барилга, угсралтын даатгалын хэлбэрийн нөхөн төлбөрийн огцом өсөлт тус тус нөлөөлсөн байна.

Хүснэгт-9

№	Даатгалын компани	Нийт нөхөн төлбөр		Өсөлт, бууралт /хувиар/
		2014.12.31	2015.12.31	
1	Ард даатгал	3,577,646,570.4	3,828,560,413.1	7.0
2	Бодь даатгал	3,511,231,755.2	3,288,566,994.4	(6.3)
3	Ган зам даатгал	76,996,223.0	97,243,433.0	26.3
4	Гэр даатгал	85,655,695.0	81,220,584.0	(5.2)
5	Мандал женерал даатгал	1,570,717,339.6	4,515,928,953.4	187.5
6	Миг даатгал	2,928,706,064.2	4,393,687,078.9	50.0
7	Монгол даатгал	9,306,552,972.1	8,090,807,762.2	(13.1)
8	Монре даатгал	1,164,143,570.0	1,700,533,168.0	46.1
9	Мөнх даатгал	190,642,399.0	74,662,534.0	(60.8)
10	Номин даатгал	2,373,915,432.6	1,599,761,174.1	(32.6)
11	Нэйшнл лайф даатгал	<b>635,411,630.1</b>	<b>943,146,048.6</b>	48.4
12	Практикал даатгал	2,371,445,388.0	2,256,227,900.8	(4.9)
13	Соёмбо даатгал	1,752,278,384.8	1,747,474,411.6	(0.3)
14	Тэнгэр даатгал	2,254,287,577.9	2,842,227,381.6	26.1
15	Улаанбаатар хотын даатгал	53,431,143.0	270,773,644.0	406.8

16	Хаан даатгал	444,287,406.0	843,936,058.0	90.0
	<b>НИЙТ</b>	<b>32,348,602,261.9</b>	<b>36,574,757,539.7</b>	<b>13.1</b>



Даатгалын хэлбэрээр нь авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 33329 гэрээнд нийт 14.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, авто тээврийн хэрэгслийн даатгалын 15787 гэрээнд 8.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон нь хамгийн өндөр нөхөн төлбөр олгосон даатгалын хэлбэрүүд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад барилга угсралтын даатгалын нөхөн төлбөр 24.6 дахин өссөн нь хамгийн өндөр өсөлттэй байна. Мөн хариуцлагын даатгал, санхүүгийн даатгал, зээлийн даатгал, хуримтлалын даатгалын хэлбэрээр тус тус өмнөх оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт-10

№	Даатгалын хэлбэр	2014.12.31		2015.12.31		НТ-ийн өсөлт, бууралт /хувиар/
		Нөхөн төлбөр	НТ авсан гэрээний тоо	Нөхөн төлбөр	НТ авсан гэрээний тоо	
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	3,345,864,797.3	9390	3,731,485,080.4	9826	11.5
2	Хөрөнгийн даатгал	2,623,806,733.0	3225	2,540,367,959.6	3200	(3.2)
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	8,184,380,004.8	15362	8,749,712,690.9	15787	6.9
4	Ачааны даатгал	175,680,614.7	58	216,507,315.9	37	23.2
5	Барилга угсралтын даатгал	62,508,630.0	5	1,544,531,059.1	3	2370.9
6	Мал амьтдын даатгал	21,633,868.9	302	69,262,281.6	68	220.2
7	Агаарын хөлгийн даатгал	94,680,384.7	6	0.0	0	-
8	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	172,891,380.0	1155	16,598,100.0	27	(90.4)
9	Хариуцлагын даатгал	616,638,566.8	898	317,915,901.7	531	(48.4)
10	Санхүүгийн даатгал	648,261,658.0	256	1,624,037,280.7	353	150.5
11	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	12,373,224,877.7	28034	14,698,934,723.6	33329	18.8
12	Зээлийн даатгал	3,386,749,113.8	122	2,097,271,497.7	495	(38.1)
13	Итгэлцлийн даатгал	0.0	0	12,104,891.0	2	-


14	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	6,870,002.3	7	12,882,709.02	13	87.5
15	Хугацаат амьдралын даатгал	86,730,330.0	100	119,486,388.1	148	37.8
16	Хуримтлалын даатгал	98,949,700.7	28	74,022,041.5	37	(25.2)
17	Тэтгэврийн даатгал	34,343,757.0	12	30,706,750.0	11	(10.6)
18	Эрүүл мэндийн даатгал	415,387,842.5	790	718,930,869.0	2145	73.1
	Нийт	<b>32,348,602,261.9</b>	<b>59750</b>	<b>36,574,757,539.7</b>	<b>66012</b>	<b>13.1</b>

Жич: Тайлант хугацаанд нөхөн төлбөр гараагүй даатгалын хэлбэрүүдийг дээрх хүснэгтэд оруулаагүй болно.

## 1.6. ДААТГАЛЫН НӨӨЦ САН

2015 онд даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ 72.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 10.2 хувиар өссөн боловч сүүлийн 5 жилийн өсөлтийн дундаж хувиас бага байна. Өсөлтийн хурд буурахад 3 даатгалын компанийн нөөц сан буурсан, мөн “Моннис даатгал” ХХК татан буугдсантай холбоотойгоор ердийн даатгалын компаниудын нийт нөөц сангийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1 тэрбум гаруй төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлсэн байна. Нийт дүнгээрээ өмнөх оны мөн үеэс өссөн нөөц сангийн өсөлтөд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн нөөц сангийн хэмжээ эерэгээр нөлөөлсөн. Даатгалын салбарын хэмжээнд “Монгол даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК, “Тэнгэр даатгал” ХХК-ууд 5 тэрбум ба түүнээс дээш төгрөгийн нөөц сантай бөгөөд эдгээрийн дүн нь нийт нөөц сангийн 51.4 хувийг эзэлж байна. Хорооноос даатгалын компаниудын нөөц сангийн актуар тооцооллыг хянаж байгаагаас гадна салбарын хөгжилтэй шууд хамааралтайгаар сүүлийн 5 жилийн хугацааны даатгалын нөөц сангийн өсөлтийг дараах графикаас харж болно.

График-8




## 1.7. ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд хохирлын харьцаа нь 32.2 хувьтай байна. Энд давхар даатгалд төлсөн хураамж болон давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг оруулж тооцсон болно. Мөн даатгалын компаниудын хувьд даатгалын цэвэр хураамжийн орлогоос тооцсон орлогод тооцсон хураамж, даатгагчаас олгосон нөхөн төлбөрийн

харьцаагаар тооцоход салбарын хэмжээнд хохирлын харьцаа 46.6 хувьтай байна. Даатгалын компани тус бүрээр авч үзвэл “Монре даатгал” ХХК-ийн хохирлын харьцаа 68.1 хувь байгаа нь хамгийн өндөр, “Мөнх даатгал” ХХК хамгийн бага буюу 18.0 хувийн хохирлын харьцаатай байна. Салбарын хэмжээнд хохирлын харьцаа зохих түвшинд байна гэж үзэж байна.

График-9



Хүснэгт-11

**Даатгалын компаниудын хохирлын харьцаа**

№	Даатгалын компани	Нийт орлогод тооцсон хураамж	Даатгагчаас олгосон нөхөн төлбөр	Хохирлын харьцаа
1	Ард даатгал	6,502,681,988.7	3,828,560,413.1	58.9%
2	Бодь даатгал	7,584,497,787.8	3,288,566,994.4	43.4%
3	Ган зам даатгал	512,568,972.2	97,243,433.0	19.0%
4	Гэр даатгал	364,785,850.5	81,220,584.0	22.3%
5	Мандал женерал даатгал	2,770,019,591.8	1,121,187,313.9	40.5%
6	Миг даатгал	8,923,713,822.7	4,354,570,873.7	48.8%
7	Монгол даатгал	16,519,161,481.7	8,090,807,762.2	49.0%
8	Монре даатгал	2,497,570,513.8	1,700,533,168.0	68.1%
9	Мөнх даатгал	415,123,698.0	74,662,534.0	18.0%
10	Номин даатгал	3,664,393,592.1	1,599,761,174.1	43.7%
11	Нэйшнл лайф даатгал	1,459,955,919.3	937,146,048.6	64.2%
12	Практикал даатгал	4,428,205,958.3	2,256,227,900.8	51.0%
13	Соёмбо даатгал	4,767,254,231.8	1,659,698,792.8	34.8%
14	Тэнгэр даатгал	6,406,127,373.6	2,755,263,850.5	43.0%
15	Улаанбаатар хотын даатгал	1,114,617,757.2	270,773,644.0	24.3%
16	Хаан даатгал	3,775,628,769.6	843,936,058.0	22.4%
	<b>Нийт</b>	<b>71,706,307,309.0</b>	<b>32,960,160,545.2</b>	<b>46.0%</b>

Хүснэгт-12

**Давхар даатгалын хураамж, нөхөн төлбөрийг оруулж тооцсон хохирлын харьцаа**

№	Даатгалын компани	Нийт орлогод тооцсон хураамж+Давхар даатгалын хураамж	Нийт нөхөн төлбөр	Хохирлын харьцаа
---	-------------------	---	-------------------	------------------

1	Ард даатгал	8,920,572,945.82	3,828,560,413.12	45.9%
2	Бодь даатгал	26,765,775,216.71	3,288,566,994.38	12.6%
3	Ган зам даатгал	517,110,111.57	97,243,433.00	19.0%
4	Гэр даатгал	426,648,875.27	81,220,584.00	22.3%
5	Мандал женерал даатгал	8,953,571,277.44	4,515,928,953.36	52.8%
6	Миг даатгал	9,818,672,623.41	4,393,687,078.90	44.0%
7	Монгол даатгал	24,221,829,656.98	8,090,807,762.22	29.1%
8	Монре даатгал	2,907,053,616.82	1,700,533,168.00	63.2%
9	Мөнх даатгал	490,329,881.00	74,662,534.00	18.0%
10	Номин даатгал	3,775,135,601.15	1,599,761,174.12	41.0%
11	Нэйшнл лайф даатгал	1,652,826,227.62	943,146,048.55	63.5%
12	Практикал даатгал	5,167,151,995.56	2,256,227,900.79	46.1%
13	Соёмбо даатгал	5,143,532,547.37	1,747,474,411.61	33.0%
14	Тэнгэр даатгал	8,413,300,046.62	2,842,227,381.63	34.0%
15	Улаанбаатар хотын даатгал	1,077,725,671.19	270,773,644.00	24.3%
16	Хаан даатгал	3,393,449,961.84	843,936,058.00	22.0%
	<b>Нийт</b>	<b>111,644,686,256.4</b>	<b>36,574,757,539.0</b>	<b>32.2%</b>

### 1.8. ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

Тайлант хугацаанд даатгалын болон давхар даатгалын компаниудын цэвэр ашиг 7.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны мөн үеэс 6 даатгалын компанийн цэвэр ашиг буурсан хэдий ч бусад компанийн хувьд цэвэр ашиг өссөн нь нийт салбарын хувьд өмнөх оны мөн үеэс өсөлт үзүүлэхэд нөлөөлж байна. Салбарын хэмжээнд цэвэр ашгийн өсөлтөд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК, “Монгол даатгал” ХХК-уудийн тайлант хугацааны цэвэр ашиг гол нөлөөлөгч хүчин зүйл болсон байна. Мөн тайлант хугацаанд “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн хувьд 244.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж хуримтлагдсан алдагдал нь 575.7 сая төгрөгт хүрсэн байна. Тус компанийн хувьд 2008 онд урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж эхэлснээс хойш алдагдалтай ажиллаж байсан бөгөөд 2014, 2015 онуудад ашигтай ажиллаж, хурамтлагдсан алдагдал нь буурч байна.

Хүснэгт-13

№	Даатгалын компани	Тайлант хугацааны цэвэр ашиг /алдагдал/		
		2014.12.31	2015.12.31	Өсөлт /бууралт/
1	Ард даатгал	538,752,092.3	-138,954,653.3	-677,706,745.6
2	Бодь даатгал	17,828,226.6	-781,910,707.2	-799,738,933.9
3	Ган зам даатгал	650,823,560.6	397,418,911.5	-253,404,649.1
4	Гэр даатгал	247,198,036.4	413,483,464.7	166,285,428.3
5	Мандал женерал даатгал	-242,707,960.0	416,933,334.0	659,641,293.9
6	Миг даатгал	410,862,616.0	763,751,469.1	352,888,853.1
7	Монгол даатгал	-1,244,787,296.2	1,639,723,358.9	2,884,510,655.0
8	Монре даатгал	100,179,526.4	275,380,369.9	175,200,843.4
9	Мөнх даатгал	156,278,097.0	218,713,962.0	62,435,865.0
10	Номин даатгал	-44,552,445.7	102,399,948.6	146,952,394.2
11	Нэйшнл лайф даатгал	40,356,043.2	244,969,411.2	204,613,368.0
12	Практикал даатгал	231,326,812.2	367,125,878.1	135,799,065.9



13	Соёмбо даатгал	-218,539,678.3	227,944,698.9	446,484,377.2
14	Тэнгэр даатгал	754,630,539.8	412,189,061.8	-342,441,478.0
15	Улаанбаатар хотын даатгал	415,485,652.9	338,712,051.6	-76,773,601.3
16	Хаан даатгал	272,423,374.1	104,775,218.0	-167,648,156.1
17	ХАА-н давхар даатгал	0.00	2,107,814,412.2	2,107,814,412.2
	<b>НИЙТ</b>	<b>2,085,557,197.5</b>	<b>7,110,470,189.8</b>	<b>5,024,912,992.4</b>

График-10




### 1.9. ДАВХАР ДААТГАЛ

Тайлант хугацаанд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь давхар даатгалын үйл ажиллагаа явуулж 446.6 сая төгрөгийн давхар даатгалын хураамж төвлөрүүлж, 185.6 сая төгрөгийг гадаадын давхар даатгагчид төлсөн байна. Харин ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд гадаадын давхар даатгагчид нийт 41.96 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг төлсөн байна. Энэ нь өмнөх оны мөн үеийн дүнгээс 10.4 тэрбум төгрөгөөр буюу 32.9 хувиар өссөн байна. Нийт даатгалын хураамжаас 36.8 хувийг нь давхар даатгалд төлсөн байгаа нь маш өндөр үзүүлэлт юм. “Бодь даатгал” ХХК-ийн хувьд давхар даатгалд төлсөн хураамж нь нийт хураамжийнхаа 68.5 хувийг, “Мандал генерал даатгал” ХХК-ийн хувьд 63 хувийг, “Монгол даатгал” ХХК-ийн хувьд 45.8 хувийг эзэлж байгаа нь нийт салбарын үзүүлэлтэд хүчтэй нөлөөлсөн. Тайлант хугацаанд давхар даатгагчаас 3.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь нийт нөхөн төлбөрийн 9.8 хувийг эзэлж байна. Сүүлийн 5 жилийн байдлаарх давхар даатгалын хураамж, нөхөн төлбөр, хураамжийн өсөлтийг дараах графикаар харуулав.

График-11

**Давхар даатгалын хураамж, нөхөн төлбөр  
/тэрбум төгрөг/**






## 2. ЕРДИЙН ДААТГАЛ

2015 оны 4 дүгээр улирлын байдлаар 15 ердийн даатгалын компани, тэдгээрийн 246 салбар, 9 төлөөлөгчийн газар Улаанбаатар хот, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

### 2.1. ЕРДИЙН ДААТГАГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ

Ердийн даатгалын 15 компанийн нийт хөрөнгийн хэмжээ тайлант хугацаанд 139.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 6.5 тэрбум төгрөгөөр буурсан байна. Сүүлийн 5 жилийн ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийг график-12-т харуулсан бөгөөд нийт хөрөнгийн 2011-2013 онуудад өссөн өсөлтийн хурд 2014-2015 онуудад буурах хандлагатай байна.




### 2.2. ЕРДИЙН ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид өр төлбөр болон эзэмшигчдийн өмчийн эзлэх хувийг дараах графикаар харуулав. Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн талаар 1.3 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

#### Ердийн даатгалын компаниудын өр төлбөр

График-13




### 2.3. ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 14 даатгалын хэлбэрээр 87.8 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлж, үүнээс давхар даатгалын хураамжид 34.2 тэрбум төгрөг төлж, 1.6 тэрбум төгрөгийн хураамжийг даатгуулагч нарт буцаан олгосноор 51.9 тэрбум төгрөгийн цэвэр хураамжийн орлого төвлөрүүлсэн байна. Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлогын талаар 1.4 дэх хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Ердийн даатгалын нийт хураамжийн орлогыг даатгалын хэлбэрээр ангилж, дараах графикаар харуулав.

График-14

**Ердийн даатгалын нийт хураамжийн орлогын бүтэц /хэлбэрээр/**



### 2.4. ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 35.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон бөгөөд энэ нь салбарын нийт нөхөн төлбөрийн 97.4 хувийг эзэлж байна. Даатгалын нөхөн төлбөрийн талаар 1.5 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Мөн давхар даатгагчаас 3.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр төлүүлсэн бөгөөд даатгагчдийн хувьд олгосон нийт нөхөн төлбөрийн 45.5 хувь буюу 16.2 тэрбум төгрөгийг даатгалын нөөц сангаас, 44.4 хувь буюу 15.8 тэрбум төгрөгийг орлогод тооцсон хураамжаас тус тус олгосон байна.

### 2.5. ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА, АШИГТ АЖИЛЛАГАА

Ердийн даатгагчдын хохирлын харьцааг өмнөх оны мөн үетэй харьцуулж харуулав.


Хүснэгт-14

№	Даатгалын компани	Хохирлын харьцаа		Өөрчлөлт
		2014.12.31	2015.12.31	

1	Ард даатгал	40.7%	58.9%	18.1
2	Бодь даатгал	40.4%	43.4%	3.0
3	Ган зам даатгал	14.5%	19.0%	4.5
4	Гэр даатгал	23.9%	22.3%	(1.6)
5	Мандал женерал даатгал	38.9%	40.5%	1.6
6	Миг даатгал	50.4%	48.8%	(1.6)
7	Монгол даатгал	49.8%	49.0%	(0.8)
8	Монре даатгал	51.9%	68.1%	16.2
9	Мөнх даатгал	33.8%	18.0%	(15.8)
10	Номин даатгал	56.2%	43.7%	(12.6)
11	Практикал даатгал	52.8%	51.0%	(1.8)
12	Соёмбо даатгал	36.6%	34.8%	(1.8)
13	Тэнгэр даатгал	36.6%	43.0%	6.4
14	Улаанбаатар хотын даатгал	27.8%	24.3%	(3.5)
15	Хаан даатгал	16.9%	22.4%	5.5
	<b>Нийт /дундаж/</b>	<b>42.0%</b>	<b>46.0%</b>	<b>3.9</b>

Тайлант хугацааны ердийн даатгалын компаниудын ашигт ажиллагааг 1.8 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Сүүлийн 5 жилийн 4 дүгээр улирлын байдлаар тайлант хугацааны цэвэр ашиг, хуримтлагдсан ашгийг дараах графикаар харуулав.

График-15



## 2.6. ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН, ДАВХАР ДААТГАЛ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нөөц сан 63.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1 тэрбум төгрөгөөр буурсан байна. Ердийн даатгалын төрлөөр нөөц сан тус бүрийн дүнг 2014 оны дүнтэй харьцуулж дараах байдлаар харуулав.


Хүснэгт-15

Ердийн даатгалын төрөл	Ердийн даатгалын нөөц сан	2014-IV	2015-IV
Сайн дурын даатгал	Орлогд тооцоогүй хураамжийн нөөцийн сан	25,222,709,427.56	21,861,572,333.97
	Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	8,651,448,775.60	7,245,310,854.89
	Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	412,875,564.45	199,279,030.51

	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	17,538,521,680.93	20,243,016,554.25
Албан журмын даатгал	Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн сан	9,320,664,280.05	10,483,926,671.98
	Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	2,173,650,926.71	2,020,899,124.13
	Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	144,423,515.50	93,975,716.12
	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	1,345,452,774.94	1,619,988,633.82
	<b>Нийт нөөц сангийн дүн</b>	<b>64,809,746,945.74</b>	<b>63,767,968,919.67</b>

График-16

### Ердийн даатгалын төрлөөр нөөц сангийн харьцаа /2015-IV/



Ердийн даатгагчид өөрийн хүлээх эрсдэлийг хэсэгчлэн гадаадын давхар даатгагчид даатгуулахад тайлант хугацаанд 41.96 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 37 хувиар өссөн байна. Давхар даатгалын талаар 1.9 дэх хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

Хүснэгт-16

№	Даатгалын компани	Давхар даатгалын хураамж		Өөрчлөлт
		2014.12.31	2015.12.31	
1	Ард даатгал	1,816,253,227.05	1,841,974,596.96	25,721,369.91
2	Бодь даатгал	9,436,735,259.86	18,479,216,645.63	9,042,481,385.77
3	Ган зам даатгал	0.00	0.00	0.00
4	Гэр даатгал	0.00	0.00	0.00
5	Мандал женерал даатгал	4,421,046,631.68	5,783,971,377.54	1,362,924,745.86
6	Миг даатгал	2,046,371,038.94	1,067,097,151.69	-979,273,887.25
7	Монгол даатгал	10,582,864,446.24	11,311,706,301.30	728,841,855.06
8	Монре даатгал	209,458,504.94	191,367,922.73	-18,090,582.21
9	Мөнх даатгал	0.00	0.00	0.00
10	Номин даатгал	270,591,949.56	238,187,741.03	-32,404,208.53

11	<b>Практикал даатгал</b>	208,639,223.24	467,280,242.83	258,641,019.59
12	<b>Соёмбо даатгал</b>	389,284,846.00	534,823,534.46	145,538,688.46
13	<b>Тэнгэр даатгал</b>	1,048,378,794.19	1,949,258,415.03	900,879,620.84
14	<b>Улаанбаатар хотын даатгал</b>	0.00	0.00	0.00
15	<b>Хаан даатгал</b>	129,232,813.00	67,779,613.89	-61,453,199.11
	<b>НИЙТ</b>	<b>30,558,856,734.70</b>	<b>41,932,663,543.09</b>	<b>11,373,806,808.39</b>


### **3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ**

#### **3.1. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ**

“Нэйшнл лайф даатгал” ХХК нь 2008 оноос хойш урт хугацааны даатгалын үйл ажиллагаа явуулж байна. Тус компанийн хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилийн байдлаар тогтмол өсөлттэй байгаа бөгөөд тайлант хугацаанд 7.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.

График-17

**Урт хугацааны даатгагчийн нийт хөрөнгө**




#### **3.2. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР**

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн даатгалын хураамжийн орлого тайлант хугацаанд 1.65 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онуудын тогтмол өсөлтийг хангасан байна. Тайлант хугацааны нөхөн төлбөр мөн өсч 943.2 сая төгрөгт хүрсэн бөгөөд урт хугацааны даатгагчийн хохирол нөхөлтийн харьцаа 63.5 хувьтай байна. Тайлант жилийн урт хугацааны даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, тэдгээрийн харьцааг сүүлийн жилүүдтэй харьцуулав.

**Урт хугацааны даатгагчийн нийт хураамжийн орлого, нөхөн төлбөр**

График-18




### 3.3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ

Давхар даатгалын хураамжид тайлант хугацаанд 24.8 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна. Урт хугацааны даатгалын сүүлийн 5 жилийн давхар даатгалын хураамжийг графикаар харуулав.

Урт хугацааны даатгалын давхар даатгалын хураамж

График-19




### 3.4. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН НӨӨЦ САН, АШИГТ АЖИЛЛАГАА

Урт хугацааны даатгалын хураамжийн орлогын тогтмол өсөлттэй холбоотой даатгалын нөөц сангийн хэмжээ нь тогтмол өсч байна. Тайлант хугацаанд даатгагчийн нөөц сан 1.47 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 13.1 хувиар өссөн байна.

Урт хугацааны даатгагчийн нөөц сан


График-20



“Нэйшнл лайф даатгал” ХХК нь 2008 оноос урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж эхэлснээс хойш алдагдалтай ажиллаж байсан бөгөөд 2014 оноос эхлэн ашигтай ажиллаж, 2015 оны 4 дүгээр улирлын байдлаар 245 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, хуримтлагдсан алдагдал нь 575.7 сая төгрөгт хүрч буурсан байна. Урт хугацааны даатгагчийн ашигт ажиллагааг сүүлийн 5 жилийн байдлаар дараах графикаар харуулав.

График-21


#### Урт хугацааны даатгагчийн цэвэр ашиг, алдагдал



#### 4. АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ


2015 оны 4 дүгээр улирлын байдлаар ердийн даатгалын 15 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /цаашид “жолоочийн хариуцлагын даатгал” гэх/-ын үйл ажиллагаа эрхэлж байна. Жолоочийн хариуцлагын даатгалаар даатгалын компаниуд тайлант улиралд 22.9 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 2.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд жолоочийн хариуцлагын даатгалын 33329 тохиолдолд нийт 14.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Албан журмын болон сайн дурын даатгалын нийт хураамжийн орлого, нийт нөхөн төлбөрийг харьцуулж харуулав.



Сүүлийн 3 жилийн статистикаас харахад жолоочийн хариуцлагын даатгалын 1 гэрээ тутамд ногдож буй даатгалын тохиолдол болох магадлал нь дараах байдалтай байна.

График-23



## 5. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

### 5.1. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

Даатгалын зуучлагч 37 компаниас 2015 онд даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулсан нь 29, огт үйл ажиллагаа явуулаагүй 8 компани байна. Тайлант хугацаанд 21 даатгалын зуучлагч компани, 8 банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж нийт 9 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий ердийн даатгалын 13, урт хугацааны даатгалын 1 бүтээгдэхүүнийг зуучилж, 24.1 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн нь салбарын нийт хураамжийн орлогын 21.1 хувийг бүрдүүлж байна. Мөн даатгалын зуучлалын орлого нь өмнөх оны мөн үеэс 36.2 хувиар өсч, 4.2 тэрбум төгрөгт хүрчээ. Даатгалын компаниуд, даатгалын зуучлагч компаниудын тайлагналаас хамаарч даатгалын зуучлагчаар дамжиж орсон даатгалын хураамжийн дүн зөрүүтэй байдаг.



**Даатгалын зуучлал  
/2015.IV/**



Хүснэгт-17

ДД	Даатгалын зуучлагч компани	2014.12.31		2015.12.31	
		Зуучилсан даатгалын хураамжийн орлого	Даатгалын зуучлалын орлого	Зуучилсан даатгалын хураамжийн орлого	Даатгалын зуучлалын орлого
1	АМЕ	680,587,803.10	68,058,780.31	0.00	120,209,247.64
2	Ай Ай Би	-	-	-	-
3	Ар Эм Ай Би	-	-	1,900,000.00	1,900,000.00
4	Ариг банк	77,429,059.20	12,263,787.91	159,527,409.76	35,089,645.51
5	Арм интернэшнл	-	-	51,717,436.00	15,521,387.04
6	Асимон брокерс	1,615,933,490.36	129,974,631.56	5,230,626,407.00	170,254,464.81
7	Ачит ундарга	412,910,881.32	118,512,686.17	358,249,192.78	75,553,041.82
8	Ваяснюь Солюшн	39,005,171.00	12,982,274.00	809,930,358.00	112,324,545.00
9	Голомт банк	-	-	1,011,429,119.67	151,714,367.95
10	Гэрэлт буян ундрах	160,927,148.00	47,880,785.00	0.00	11,216,170.50
11	Дэвжих дэлгэрэх холдинг	4,221,000.00	1,266,300.00	21,127,870.00	3,164,533.00
12	Капитал банк	82,669,766.02	16,966,488.36	652,477,689.38	100,989,237.18
13	Лоялти солюшн	856,448,058.80	263,396,000.00	40,607,218.00	12,689,514.36
14	Мастер шийдэл	-	-	86,223,050.00	20,776,732.15
15	Монгол бичээч зууч	-	-	41,287,239.00	11,945,155.90
16	Монголиан интернэшнл брокерс	-	-	-	-
17	Монголиан иншуранс брокерейж	-	-	-	-
18	Нэйшнл эженси	125,038,620.00	37,511,584.00	458,298,585.00	73,920,770.00
19	Ренессанс групп	302,185,607.15	51,274,262.42	228,534,122.00	33,323,221.26
20	Си эн эн икс	3,741,373,051.93	195,355,162.66	500,496,408.24	146,116,987.97
21	Соёомбо Ай Би	17,273,621.95	4,889,707.20	1,989,327.00	516,081.90
22	Сүрэг хараацай	497,392,680.00	108,155,121.00	1,865,653,545.00	447,529,733.00
23	Тод капитал	-	-	-	-
24	Төрийн банк	797,705,357.18	180,182,516.87	1,372,002,984.46	298,024,643.06
25	Тус брокерс	-	-	-	-
26	Түвшин ориент	-	-	-	-
27	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	-	-	1,861,114,646.28	481,973,051.05

28	Хаан банк	3,400,963,928.00	662,203,343.00	2,392,942,438.00	534,898,901.00
29	ХасБанк	353,705,337.19	70,725,597.90	1,491,658,379.46	298,152,594.39
30	Худалдаа хөгжлийн банк	434,798,355.82	52,099,986.93	2,949,587,901.96	421,899,952.01
31	Хүннү сизл	32,981,101.00	16,733,467.60	17,283,262.90	4,231,554.27
32	Цагаан гэрэлт	-	-	44,725,483.00	11,044,275.00
33	Эй Эс Ай Би	1,435,850.00	405,128.00	-	-
34	Эл Би брокерэж	-	-	66,335,482.00	9,391,877.00
35	Эм жи ай би	-	-	7,522,720.00	1,504,544.00
36	Эрсдэлийн шийдэл	3,957,661,270.25	1,151,273,626.78	2,359,006,033.68	639,199,680.47
37	Эс ай би эс	300,000.00	100,000.00	-	-
	<b>Нийт</b>	<b>17,592,947,158.27</b>	<b>3,202,211,237.67</b>	<b>24,082,254,308.57</b>	<b>4,245,075,909.24</b>

*Тэмдэглэл: - үйл ажиллагаа эрхлээгүй 8 компани*

*Жич: 2015 оны дүнг тодруулж тэмдэглэсэн компаниудын хувьд 2015 оны 4 дүгээр улирлын байдлаар тайлангаа ирүүлээгүй тул 2015 оны 3 дугаар улирлын дүнгээр нэгтгэсэн болно.*

## 5.2. ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Даатгалын хохирол үнэлэгч 27 компаниас 2015 онд 22 компани үйл ажиллагаа явуулж тайлант хугацаанд нийт 9.6 тэрбум төгрөгийн даатгалын хохирлын хэмжээ бүхий 24391 удаагийн даатгалын хохирлын үнэлгээ хийж, 640.4 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлого төвлөрүүлжээ. Нийт дүнгээрээ даатгалын хохирол үнэлгээний орлого нь өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өссөн байна.

Хүснэгт-18

№	Компани	2015.12.31			2015.12.31		
		Даатгалын хохирол үнэлгээний тоо	Үнэлсэн даатгалын хохирлын хэмжээ	Даатгалын хохирол үнэлгээний орлого	Даатгалын хохирол үнэлгээний тоо	Даатгалын үнэлсэн хохирлын хэмжээ	Даатгалын хохирол үнэлгээний орлого
1	Арвижих эстимэйт	1726	1,122,187,493	35,046,950.0	1,267	804,279,314	27,218,700.0
2	Арга билэг эстимэйт	41	40,575,200	1,183,000.0	99	93,555,077	2,407,000.0
3	Ашид билгүүн	9507	227,669,550	223,358,550.0	7,500	1,270,460,000	206,638,109.1
4	Бэт эстимэйт	573	579,331,900	15,864,545.5	202	416,515,018	11,300,000.0
5	Вендо	5254	2,369,725,439	116,445,091.0	5,839	2,010,755,943	133,089,536.6
6	Гэрэгэ эстимэйт	3864	2,310,970,509	86,320,024.0	2,442	1,359,742,271	62,592,136.0
7	Жи эй си си	785	338,062,603	15,306,363.6	555	415,261,326	14,395,454.5
8	Итгэлт эстимэйт	1967	1,839,576,748	54,036,419.0	600	411,464,886	13,473,637.0
9	Капитал эстимэйт	5	4,436,500	95,000.0	37	16,302,900	860,000.0
10	Лэнде	559	271,305,776	13,526,895.5	1,421	490,681,464	32,488,000.0
11	Мастер Үнэлгээ	390	203,164,029	9,566,000.0	981	538,264,040	27,482,000.0
12	Мега марз	510	258,272,042	10,392,682.0	196	165,293,339	4,680,000.0
13	Сэлэнгэ эстимэйт	846	500,371,028	21,702,000.0	129	49,646,360	3,256,000.0
14	Тэгшсонгол т эстимэйт	40	32,791,000	1,455,000.0	43	42,828,900	1,239,090.9
15	Ухаашүрт консалтин	496	225,361,101	7,433,500.0	798	351,153,000	27,858,181.0
16	Файн эстимэйт	142	173,530,220	5,230,000.0	121	167,985,220	2,700,000.0

17	Фэйр валуэши	566	364,224,570	13,856,700.0	744	434,105,300	20,571,000.0
18	Хос стандарт	303	150,026,300	5,996,500.0	263	81,304,200	7,850,000.0
19	Хөрөнгө үнэлгээний төв	30	15,489,400	920,000.0	29	14,938,000	890,000.0
20	Юу Энд Эн	0	0.0	0.0	-	-	-
21	Кости эстимэйт	-	-	-	976	359,429,460	20,564,000.0
22	БАНХАС	-	-	-	149.00	84,599,680	3,645,000.0
23	Хас үнэлгээ	-	-	-	-	-	-
24	Хөрөнгө эстимэйт	-	-	-	0.00	0.0	15,235,000.0
25	Аа аперейзал	-	-	-	-	-	-
26	Тэнцвэр эстимэйт	-	-	-	-	-	-
27	Виннэрвэй	-	-	-	-	-	-
	<b>Нийт</b>	<b>27604</b>	<b>11,027,071,408</b>	<b>637,735,220.5</b>	<b>24391</b>	<b>9,578,565,698</b>	<b>640,432,845.1</b>


*Тэмдэглэл: - үйл ажиллагаа эрхлээгүй 5 компани*

*Жич: Тоон мэдээллийг нь тодруулсан хохирол үнэлэгч компаниудын хувьд 2015 оны 4 дүгээр улирлын байдлаар тайлангаа дутуу болон огт ирүүлээгүй тул дээрх тоон мэдээллийг 2015 оны 3 дугаар улирлын дүнгээр нэгтгэсэн болно.*

Даатгалын хохирол үнэлгээний орлогын сүүлийн 3 жилийн статистикийг дараах графикаар харуулав.

График-25

#### Даатгалын хохирол үнэлгээний орлого



## 6. ДҮГНЭЛТ

Монгол улсын даатгалын салбарын 2015 оны санхүү, даатгалын үйл ажиллагааны нэгдсэн танилцуулгыг эмхэтгэж, салбарын гол үзүүлэлтүүдийг сүүлийн жилүүдийн үзүүлэлтүүдтэй харьцуулж, дүгнэлээ.

2015 онд давхар даатгалын болон даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 173.2 тэрбум төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 80.6 хувийг ердийн даатгалын компаниуд, 4.4 хувийг урт хугацааны даатгалын компани, 15 хувийг давхар даатгалын компани эзэлж байна. Нийт хөрөнгийг өмнөх онтой харьцуулахад 13.6 хувиар өссөн байна. 2015 оны жилийн эцсийн байдлаар даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөр 5.5 тэрбум төгрөгөөр буурч, нөөц сан 6.7 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 19.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Өмнөх оны мөн үеэс хамгийн өндөр өсөлт үзүүлж 26.0 хувиар өссөн эзэмшигчдийн өмчийн өсөлтөд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн эзэмшигчдийн өмчийн хэмжээ гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант хугацаанд даатгалын компаниуд 113.9 тэрбум төгрөгийн даатгалын нийт хураамжийн орлого төвлөрүүлж, 36.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Мөн даатгалын нийт хураамжийн орлоготой шууд хамааралтайгаар даатгуулагчийн тоо, даатгалын хураамж, нөхөн төлбөр зэрэг гол үзүүлэлтүүдийн хувьд ч сүүлийн 5 жилийн өсөлттэй харьцуулахад өсөлтийн хурд нь удааширсан байна. Даатгалын компаниудын ашиг өсөж, тайлант хугацааны цэвэр ашиг 7.1 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд цэвэр ашигт гол нөлөөлөх харьцаануудыг тооцож үзвэл салбарын хэмжээнд нийт хөрөнгийн өгөөж 47.4 хувь, үндсэн үйл ажиллагааны зардлын харьцаа 66.5 хувь, хохирлын харьцаа 46 хувь, зардал ба хохирлын хосолсон харьцаа 112.5 хувьтай байна. Энэ нь даатгагч нар даатгалын хураамжийн хувь хэмжээг судалгаа үндэслэл муутай бага хэмжээгээр тогтоож байгаа, мөн зардлын хэмжээ нэмэгдсэн нь хохирлын хосолсон харьцаанд нөлөөлсөн харагдаж байна. Иймд даатгагч нар даатгалын бүтээгдэхүүний хураамжийн хувь хэмжээг судалгаа мэдээлэл дээр үндэслэж, актуарын аргачлалын дагуу тооцож, зардлаа бууруулж ажиллах шаардлагатайг харуулж байна.


Тайлант хугацаанд даатгалын мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааг авч үзвэл даатгалын нийт хураамжийн орлогын 40 гаруй хувийг даатгалын төлөөлөгч, 20 орчим хувийг даатгалын зуучлагч төвлөрүүлжээ. Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд 24391 даатгалын тохиолдлын хохирлыг үнэлж, 640.4 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлого төвлөрүүлжээ.

Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчдын тоо өсч, үйл ажиллагааны цар хүрээ тэлж даатгалын хүртээмжийг нэмэгдүүлж байгаа боловч даатгалын мэргэжлийн үйл ажиллагаа учир дутагдалтай байна. Энэ нь даатгуулагчдын санхүү, даатгалын талаарх мэдлэг, даатгалын нөхөн төлбөртэй холбоотой маргаан үүсэхэд даатгуулагчийн хувьд байгуулсан даатгалын гэрээнийхээ нөхцлийн талаар сайн ойлголтгүй эсвэл гэрээ байгуулсан даатгалын менежер, төлөөлөгч, зуучлагчаас мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа авч чадахгүй байгаа, мөн даатгалын хохирол үнэлгээтэй холбоотой маргаан, өргөдөл гомдлын давтамж их байдаг зэргээс илэрч байна.

Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүрүүд болох даатгалын нэвтрэлт, нягтрал нь олон улсын дунджаас харьцангуй доогуур үзүүлэлттэй, мөн сүүлийн жилүүдэд тодорхой өсөлт ажиглагдахгүй байна. 2015 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын нийт хураамжийн орлого ДНБ-ний 0.5 орчим хувийг эзэлж, нэг хүнд ногдох даатгалын нийт хураамжийн орлого ойролцоогоор 37.3 мянган төгрөг болж өссөн байна.

Даатгалын нэвтрэлт, нягтрал

График-26



Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүдийн өсөлтийн хурд буурч байгааг улс орны эдийн засгийн нөхцөлтэй уялдуулж болох боловч гол нөлөөлж буй хүчин зүйл нь зах зээлийн хамрах хүрээ юм. Салбарын хэмжээнд 2011-2013 оны хооронд гарсан огцом өсөлт нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай шууд хамааралтай байсан. Гэвч сүүлийн 2 жилийн хугацаанд салбарын хэмжээнд өсөлтийн хурд буурч байгаа нь зах зээлийн хамрах хүрээ төдийлөн тэлэхгүй байгаатай холбоотой тул цаашид төрөөс баримтлах бодлого, зохицуулалтыг салбарын үйл ажиллагааны болон зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх, урт хугацааны даатгалын хөгжил, ердийн даатгалын бүтээгдэхүүний хүртээмжийг дээшлүүлэх, албан журмын даатгалын шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх талаар судлах, иргэдийн даатгалын боловсролыг дээшлүүлэх зэрэг асуудлуудад чиглүүлэх шаардлагатай байна.

## ДААТГАЛЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР